
	(ШУТИС-ийн Өмнөговь аймаг дахь Технологийн дээд сургуулийн харьяа Политехник коллеж)	Захирлын 2026 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн ... ^{1/107} ... тоот тушаалын хоёрдугаар хавсралт	
Баталсан: ШУТИС-ийн Өмнөговь аймаг дахь Технологийн дээд сургуулийн харьяа Политехник коллежийн Захирал  (Ч.Эрдэнэтуяа)		Баталсан огноо: 2026.01.14	Хуудасны тоо: 6
Баримт бичгийг хариуцагч: Жаргалсайхан Мөнхжаргал		Танилцах албан тушаалтнууд: Нийт албан хаагчид	

ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР

Эх хувь

Баримтжуулсан мэдээллийн дугаар:
Хувилбарын дугаар: **V1.2026**

Түгээлт


Энэхүү хөтөлбөр нь манай сургуулийн өмч юм. Уг баримт бичгийг бичгээр зөвшөөрөл аваагүй үед бүхэлд нь эсвэл хэсэгчлэн байгууллагаас гадагш түгээхгүй.

Энэ хөтөлбөрийн батлагдсан албан ёсны хяналттай хуулбар нь цаасан хэлбэрээр бичиг хэргийн ажилтны баримт бичгийн хавтсанд мөн байгууллагын сервер компьютерт PDF файлаар хадгалагдана. Уг PDF файл зөвшөөрөгдсөн бүх ажилтнууд болон сонирхогч талуудад нээлттэй байна.

Дээр дурдсанаас бусад бүх цаасан болон цахим хуулбарыг зөвхөн лавлагаа болгон ашиглах хяналтгүй хуулбар гэж үзнэ.

Зөвшөөрөл

Гарын үсэг нь удирдлагын тогтолцооны энэхүү хөтөлбөрийг хянаж, зөвшөөрснийг гэрчлэх бөгөөд гарын үсэг зурсан талууд энд агуулагдаж буй бүх шаардлагуудыг мэдэж, тэдгээрийн хэрэгжилтийг хангах үүрэг хүлээсэн болохыг харуулна.

	Албан тушаал	Овог нэр	Огноо	2026.01.14
Боловсруулсан	Хүний нөөц, гадаад харилцаа хариуцсан ажилтан	Батбуян Буянжаргал	2024.05.20	
Хянасан	ДЧБСХААжилтан	Энх-Амгалан Шинэжаргал	2024.05.20	
Зөвшөөрсөн	ШУТИС-ийн Өмнөговь аймаг дахь Технологийн дээд сургуулийн харьяа Политехник коллежийн Захирал	Чимэд Эрдэнэтуяа	2026.01.14	

НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТИЙН БҮРТГЭЛ

Хөтөлбөрийн өөрчлөлт нь процесс болон бусад бодлогын баримт бичгүүдтэй уялдаж байгаа эсэхийг хянаж баталгаажуулна. Өөрчлөлтийн агуулга хэсэгт хөтөлбөрт орсон өөрчлөлтийг тэмдэглэнэ.

Өөрчлөлт оруулсан бүлэг	Өөрчлөлтийн товч утга	Хувилбарын дугаар	Сүүлд шинэчлэгдсэн огноо	Боловсруулж, шинэчилсэн албан тушаалтан, овог, нэр	Баталсан албан тушаалтан, овог, нэр

АГУУЛГА

НЭГ.Удиртгал	
1.1.Хөтөлбөр боловсруулах нийтлэг үндэслэл, эрх зүйн орчин.....	1
1.2.Хөтөлбөрийн үзэл санаа, хамрах хүрээ.....	1
1.3.Хөтөлбөрийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт.....	1-2
ХОЁР.Хөтөлбөрийн зорилго, зорилт, зарчим	2
2.1.Хөтөлбөрийн зорилго, зорилт.....	2
2.2.Хөтөлбөр хэрэгжүүлэхэд баримтлах зарчим.....	2
2.3.Багшийн цогц чадамжийн хүрээ.....	3
ГУРАВ.Хөтөлбөрийн удирдлага, санхүүжилт	3-4
3.1.Багшийн хөгжлийн төвийн үйл ажиллагаа.....	4
3.2.Хөтөлбөрийн үр нөлөө, шалгуур үзүүлэлт.....	4-5
3.3.Хөтөлбөрийн хяналт, шинжилгээ, үнэлгээ.....	5-6



Нэг.Удиртгал

1.1.Хөтөлбөр боловсруулах нийтлэг үндэслэл, эрх зүйн орчин

1.1.1.2016 онд батлагдсан Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэд баримтлала-2030-д “тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн дээд боловсролын тогтолцоог хөгжүүлж, насан туршийн боловсролын тогтолцоог боловсронгуй болгох” зорилгыг дэвшүүлсэн.

1.1.2.2018 онд батлагдсан Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 6.1-д “Багшийн мэдлэг, боловсрол, хандлага, ёс зүй, эрүүл мэнд, нийгмийн баталгаа, багшийн үнэлэмжийг нэмэгдүүлэх, мэргэжлийн ур чадварыг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөртэй байна” хэмээн заасан.

1.1.3.Мөн хуулийн 7.1-д “Бүх шатны боловсролын сургалтын байгууллага нь багшийн хөгжлийн төвтэй байна” гэж заасан нь багшийн хөтөлбөрийг боловсруулах эрх зүйн үндэслэл юм.

1.2.Хөтөлбөрийн үзэл санаа, хамрах хүрээ

Багшийн хөгжлийн хөтөлбөрт багшийн мэргэжил, арга зүйн хөгжлийг цогцоор нь шийдвэрлэх, тасралтгүй хөгжих боломжийг бүрдүүлэхэд шаардлагатай орчин, нөхцөлийг сайжруулах, үнэлгээ, урамшлууллын нэгдсэн тогтолцоог хөгжүүлэх зэргээр багшийн чадамж, ажлын үр дүнг дээшлүүлэн алсын хараанд хүрэх үзэл санааг баримтална.

1.3.Хөтөлбөрийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт

Хөтөлбөрийн үр дүн

1.3.1.Багшийн хөгжлийг дэмжих эрх зүйн орчин, тогтолцоог бүрдүүлсэн байна.

1.3.2.Багш нарын мэргэжил, гадаад хэл, мэдээллийн технологи, ур чадвар нэмэгдсэн байна.

1.3.3.Багш нар инновацид суурилсан сургалтын арга, технологийг эзэмшсэн байна.

1.3.4.Зэрэг хамгаалсан багшийн тоо нэмэгдсэн байна.

1.3.5.Багш нарын цалин хөлсийг засгийн газрын тогтоол шийдвэртэй уялдуулан нэмэгдсэн байна.

Хөтөлбөрийн үр дүнг дараах шалгуур үзүүлэлтээр тооцно

1.3.6.Багшийн хөгжүүлэхэд чиглэсэн эрх зүйн баримт бичгийн тоо, төрөл;

1.3.7.Багшийн хөгжлийн хөтөлбөрт зарцуулсан үйл ажиллагааны төрөл, тоо, зардлын хэмжээ мөнгөн дүнгээр;



№ Х-4-001
Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр
Хадгалалт: Эх хувь, байгууллагын
мэдээллийн санд

Баталсан огноо: 2026-01-14
Хувилбар: V1.2026
Нууцын зэрэг: Нээлттэй

- 1.3.8.Багшийн хөгжлийн хөтөлбөрт хамрагдсан багш нарын тоо;
- 1.3.9.Багшийн хөгжилд зориулсан сургалтын төрөл, тоо;
- 1.3.10.Зэрэг хамгаалсан багшийн тоо;
- 1.3.11.Сургуулиас мэргэжлийн зэргээ хамгаалахад дэмжлэг үзүүлсэн багшийн тоо;
- 1.3.12.Үндэсний болон олон улсын төсөл, эрдэм шинжилгээний хуралд оролцсон багшийн тоо;
- 1.3.13.Багш нарын цалин хөлсийг нэмэгдүүлсэн хувь, хэмжээ;

Хоёр.Хөтөлбөрийн зорилго, зорилт, зарчим

2.1.Хөтөлбөрийн зорилго, зорилт

ШУТИС-ийн Өмнөговь аймаг дахь Технологийн дээд сургуулийн харьяа Политехник коллежийн Бүс нутгийн хөдөлмөрийн зах зээлд шаардлагатай мэргэжилтэнг чанартай бэлтгэж, сургалтын агуулга, хөтөлбөрийг сайжруулах зорилгын хүрээнд багш, ажилчдыг чиглүүлж тэднийг тогтвортой ажилуулах бодлого баримтлана мөн ажлын үнэлгээ, урамшууллын системийг сайжруулна, багш, ажилтанд шаардлагатай хэл, соёл, сэтгэл зүйн болон бусад дэмжлэгийг үзүүлнэ зэрэг зорилтуудын хүрээнд багшийн судалгаа, сургалт, хувь хүний цогц чадамжийг тасралтгүй хөгжүүлэх боломж нөхцөлийг хангахад хөтөлбөрийн зорилго чиглэн дараах зорилтыг хэрэгжүүлнэ. Үүнд:

Зорилтууд

1. Багш, ажилчдын тасралтгүй хөгжлийг удирдлагын шатанд бодлогоор дэмжих, багш, ажилчдыг хөгжүүлэх байгууллагын соёлыг хөгжүүлэх;
2. Багшийн судалгааны чадамжийг нэмэгдүүлэх, судлаач багшийг хөгжүүлэх;
3. Багшлахуйн цогц чадамж, чадавхийг нэмэгдүүлэх, сургах, суралцах үйл ажиллагааг сайжруулах;
4. Багш ажилчдын хувь хүний цогц чадамжийг хөгжүүлэх;

2.2.Хөтөлбөр хэрэгжүүлэхэд баримтлах зарчим

1. Хөтөлбөрийн бодлого, үйл ажиллагаа нь төрөөс боловсролын талаар баримтлах бодлого, үндсэн чиглэл, ПК-ийн хөгжлийн зорилтуудад нийцсэн байх;
2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа нээлттэй, хүртээмжтэй, шударга байж, хүний эрх, жендерийн тэгш байдлыг хангах;
3. Хөтөлбөрийн тасралтгүй, тогтвортой, нэгжүүдийн хамтын ажиллагааг уялдуулан хэрэгжүүлэхэд нэгдсэн удирдлагаар хангах;

2.3.Багшийн цогц чадамжийн хүрээ



№ X-4-001
Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр
Хадгалалт: Эх хувь, байгууллагын
мэдээллийн санд

Баталсан огноо: 2026-01-14
Хувилбар: V1.2026
Нууцын зэрэг: Нээлттэй

Политехник коллежийн багш, ажилчдын хөгжлийг жил бүрийн төлөвлөгөө, хэрэгжүүлэх үйл ажиллагааг багшийн цогц чадамжид тулгуурлан төлөвлөж, зохион байгуулна. Цогц чадамж нь багшийн мэдлэг, чадвар, хандлагыг тодорхойлно.

Багш нь судалгааны, сургалтын, хувь хүний гэсэн үндсэн 3 цогц чадамжийн хүрээнд тасралтгүй хөгжинө.

- Судалгааны цогц чадамж: Багш нь шинжлэх ухааны мэргэшсэн салбарын болон салбар дундын судалгааг олон улсын жишигт нийцүүлэн гүйцэтгэх мэргэжлийн өргөн бөгөөд гүнзгий мэдлэг, судалгааны арга зүй, ёс зүйг эзэмшсэн судлаач, эрдэмтэй байна.
- Сургалтын цогц чадамж: багш нь сургах, суралцах үйл ажиллагааг шинжлэх ухааны үндэстэй, орчин үеийн сургалтын технологи, мэдээллийн хэрэгслийн дэвшилтэт хэлбэр, арга зүйд үндэслэн үр дүнтэй зохион байгуулах чадвартай байна.
- Хувь хүний цогц чадамж: Багш нь хувь хүний олон талт зөөлөн ур чадварыг өндөр түвшинд эзэмшсэн байхын зэрэгцээ байгууллагын соёл, үнэт зүйлийг эрхэмлэдэг, ёс зүйтэй, нийгмийг соён гэгээрүүлэгч бие хүн байна.

ПК-ийн багшийн цогц чадамжийн хүрээ



Гурав.Хөтөлбөрийн удирдлага, санхүүжилт

Багш ажилчдын тасралтгүй хөгжлийг удирдлагын шатанд бодлогоор дэмжих, багш, ажилчдыг хөгжүүлэх байгууллагын соёлыг хөгжүүлэх зорилтын хүрээнд:

- Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад удирдлагын нэгдсэн бодлогоор дэмжих;
- Багш, ажилчдын хөгжлийн төлөвлөгөөг хичээлийн жил бүр хэлэлцэн боловсруулан хэрэгжүүлэх;
- Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад төсөв санхүүгээр тууштай дэмжих;



№ X-4-001
Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр
Хадгалалт: Эх хувь, байгууллагын
мэдээллийн санд

Баталсан огноо: 2026-01-14
Хувилбар: V1.2026
Нууцын зэрэг: Нээлттэй

Багшийн судалгааны чадамжийг нэмэгдүүлэх, судлаач багшийг хөгжүүлэх зорилтын хүрээнд:

- Багшийн судалгааны арга зүйг сайжруулах, судлаачийн ёс зүйг төлөвлүүлэх, судалгааны төсөл, хөтөлбөр боловсруулах хэрэгжүүлэх, судалгаа удирдах зэрэг чиглэлээр сургалт зохион байгуулах, зөвлөх үйлчилгээ үзүүлэх;
- Багш судалгааны ном, сурах бичиг хэвлүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх;
- Мэргэжлийн сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх, судалгааны төсөл боловсруулах зэрэгт шаардлагатай академик мэдлэг чадварыг сайжруулахад чиглэсэн сургалт зохион байгуулах, хянан засварлах үйлчилгээ үзүүлэх;

Багшлахуйн цогц чадамж, чадавхийг нэмэгдүүлэх, сургах, суралцах үйл ажиллагааг сайжруулах зорилтын хүрээнд:

- Багшийн сургалтын арга зүйн мэдлэг, ур чадварыг шинэ шатанд гаргахад чиглэсэн сургалт зохион байгуулах, зөвлөн чиглүүлэх үйлчилгээ үзүүлэх;
- Сургах, суралцах үйл ажиллагааг шинжлэх ухааны үндэстэй, шинэлэг арга зүйгээр зохион байгуулах зорилгоор сайн туршлагыг нэвтрүүлэх;
- Дээд боловсролын сургах, суралцах үйл ажиллагаа, багшийн хөгжлийн хэрэгцээ, шаардлага, орчин үеийн хандлага, инновацийн чиглэлээр судалгаа хийх;
- Багш нарын харилцан суралцах бодит боломжийг бүрдүүлэх;
- Цахим болон холимог сургалтын загвар, сургалтын нээлттэй нөөц материал ашиглах, боловсруулах арга зүйн сургалт зохион байгуулах;

3.2.Хөтөлбөрийн үр нөлөө, шалгуур үзүүлэлт

Багшийн хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг багшийн цогц чадамжийн хүрээгээр тодорхойлно.

3.2.1.Бодлого, төлөвлөлтийн түвшинд:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай удирдлага зохион байгуулалт, санхүү, орчин нөхцөлөөр хангах асуудлыг шат шатанд дэмжсэн удирдлагын нэгдсэн тогтолцоо бий болно.
- Багш бүрийн сургалт, судалгаа, хувь хүний хөгжлийн хэрэгцээнд үндэслэн хөгжлийн хувийн төлөвлөгөө нь тэнхим болон тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу байна.



3.2.2. Судалгааны түвшинд:

- Багш нар судалгаа хийх, удирдах арга зүйн хувьд чадавхжиж, судлаачийн ёс зүй, академик эрх чөлөөг дээдэлсэн байгууллагын соёл төлөвшинө.
- Багш судалгааны бүтээл хэвлүүлэх, өндөр үр бүтээмжтэй багшийг урамшуулан санхүүгийн дэмжлэг үзүүлдэг тогтолцоог боловсронгуй болгоно.
- Эрдмийн зэрэг хамгаалахад нь удирдлага, санхүүгээр дэмжих тогтолцоог бий болгож, улмаар эрдмийн зэрэг, цолтой багшийн тоо өснө.

3.2.3. Сургалтын түвшинд:


- Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг орчин үеийн шаардлагад нийцүүлэн боловсруулах, судалгаанд суурилсан сургах, суралцах үйл ажиллагааг хөгжүүлэх, сургалтад технологийн дэвшилтэт арга, хэлбэрийг ашиглах, цахим болон хосолсон сургалтын арга зүйг нэвтрүүлэх зэргээр сургах, суралцах үйл ажиллагааг шинжлэх ухааны үндэстэй зохион байгуулах чадвартай багшийн тоо нэмэгдэж суралцагсдын сэтгэл ханамж нэмэгдэнэ.
- Хичээлийн хөтөлбөрийг шинэ, шинэлэг арга зүйгээр баяжуулах, суралцагчдыг сэдэлжүүлэх, хувь хүний хандлагыг төлөвшүүлэхэд чиглэсэн идэвхтэй сургалтын аргыг сургалтад хэрэглэх, суралцагчдын мэдлэг, чадвар, хандлагыг бодитой үнэлэх, дэвшилтэт арга, хэлбэрийг хэрэглэх, турших зэргээр сургах, суралцах үйл ажиллагааны инновацийг хөгжүүлсэн багшийн урамшуулан дэмждэг тогтолцоо бий болно.

3.2.4. Байгууллагын соёл, хувь хүний түвшинд:

- Багш, ажилчдын болон хувь хүний ёс зүйн дүрэм журмыг чанд мөрддөг хариуцдагатай, хамт олны өмнө хүлээх эрх үүргээ биелүүлдэг тогтолцоо бий болно.
- Байгууллагын хэм хэмжээ үнэт зүйлсийг эрхэмлэн дээдэлж, хамт олон, нийгэмд мэргэжлийн ур чадвар, мэдлэг, эерэг хандлагаар үлгэрлэн, нийгмийг соён гэгээрүүлэх үүрэг, хүлээлт бүхий соёл төлөвшинө.
- Багш, ажилчдын ажлын үнэлгээ, албан тушаалын зэрэглэл тогтоох, удирдах ажилтныг судлан шалгаруулах багш, ажилчдын хувь хүний ёс зүй, ур чадвар, хандлагыг харгалзан үнэлдэг тогтолцоо бий болно.

3.3. Хөтөлбөрийн хяналт, шинжилгээ, үнэлгээ:

- Хөтөлбөрийг удирдлага, зохион байгуулалтаар хангах, хэрэгжилтийг зохицуулах үүргийг Сургалтын алба, Захиргаа аж ахуйн алба нар хэрэгжүүлнэ.

 ӨМНӨГОВЬ ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ	№ X-4-001 Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр Хадгалалт: Эх хувь, байгууллагын мэдээллийн санд	Баталсан огноо: 2026-01-14 Хувилбар: V1.2026 Нууцын зэрэг: Нээлттэй
--	---	---

- Хөтөлбөрийн хэрэгжилтэд Дотоод чанарын баталгаажилт статистик хариуцсан ахлах ажилтан хяналт, дүн шинжилгээ хийж Захирлын дэргэдэх зөвлөлд танилцуулна.
- Хөтөлбөрийн хяналт шинжилгээ, үнэлгээний үр дүн, зөвлөмжийг үндэслэн хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөө, шалгуур үзүүлэлтэд нэмэлт өөрчлөлт оруулна.